



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/373

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн XII/21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Аймгийн төвийн гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэлийн хэмжээг нэмэгдүүлэх (Булган сумын Хужир толгойгоос отоглох цэг хүртэл) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан "Сервис по сименс" ХХК-тай 455 185 000 /Дөрвөн зуун тавин таван сая нэг зуун наян таван мянга/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Сервис по сименс" ХХК-ийн захирал (Ш.Мөнхсайхан)-д даалгасугай.

4. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг холбогдох байгууллагын дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010373

Аймгийн Засаг даргын 2023 оны 05. сарын
15 өдрийн 1/22 дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	8,273,726	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн албаны зардал	8,273,726	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	4,136,863	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул зураг төслийн ажлын дүн	3,701,100	Ү.Бямбасүрэн
5	Алданги	Хоногт гэрээний үнийн 0.1 хувь, нийт алданги гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
6	Ажил гүйцэтгэх хугацаа	60 хоног	Ү.Бямбасүрэн
7	Гүйцэтгэлийн баталгаанй дүн	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь.	Д.Батцогт
	Оро нутгаас авч ажиллах ажилчдын тоо	5 хүн	Н.Батжаргал